

7/21 - 2011 он
(1х) 124



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2011 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 417

Улаанбаатар хот

**Сургалтын төрийн сангийн зээлээр
гадаадад суралцуулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 177 тоот тогтоолоор баталсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2011 оны ХЭГ/1235, ХЭГ/1416 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүгд Найрамдах Солонгос Улсын Квангвооны их сургуульд электорник ба мэдээлэл зүйн инженерийн мэргэжлээр суралцаж байгаа Гочоогийн Нямдоржийг ✓
2 жилийн, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тонжи их сургуульд барилгын инженерийн мэргэжлээр суралцаж байгаа Баатардоржийн Мөнхбаясгаланг ✓
2 жилийн, АНУ-ын Калифорнийн Холливүүдийн урлагийн дээд сургуульд кино урлаг, үйлдвэрлэлийн мэргэжлээр суралцаж байгаа Баасанжавын Хуланг ✓
3 жилийн хугацаатайгаар Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР